



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А149

Хажуу шинэ-Ус

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалт, Сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн 1 дүгээр хуралдааны шийдвэр, Дундговь аймгийн зүүн бүсийн төрийн албан хаагчдын зөвлөгөөний удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн албан хаагчийн чадавхыг бэхжүүлэх төрийн залгамж холбоо, харилцан туршлага солилцох, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх арга хэмжээнд Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдыг идэвхтэй оролцохыг даалгасугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардах 2,000,000.00 (Хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Нягтлан бодогч (У.Сүнжидмаа) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Т.АРИУНАА

482401049